



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 721

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй 2 нэрийн, нийт 3,673,296.77 (гурван сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Цагааннуур чөлөөт бүсийн захирагч Б. Нурбек нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
724...дугаар тогтоолын хавсрал

**ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| № | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо хэмжээ (ширхэг г) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | |
|----------|-------------------------------|---------------------------|----------------|----------------------------|--------------------------------|---|----------------------------|--|
| 1 | Хөрс боловсруулах машин | 1/1/2014 | Ширхэг | 3,660,000.00 | 1 | 3,660,000.00 | 0 | |
| 2 | Суурин Компьютер хаалт | 12/30/2005 | Ширхэг | 13,296.77 | 1 | 13,296.77 | 0 | |
| Нийт дүн | | | | | | | 3,673,296.77 | |
| | | | | | | (гурван сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө) | | |